

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2025.09.17

Бат-Өлзий

2025 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 40 минутад сумын Соёлын төвд Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 2024 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх Нийтийн сонсголын үйл ажиллагаа эхлэв.

Төсвийн хяналтын нийтийн сонсголын зохион байгуулагчаар иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга Ц.Чинбаяр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сонсгол даргалагчаар ИТХ-ын төлөөлөгч Г.Ганчимэд, дуудагдаж ирсэн албан тушаалтнаар сумын Засаг дарга Н.Орхонтуул, Сум дундын Ой ангийн дарга Д.Очирхуяг, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Янжиндулам, Сум дундын Ой ангийн ойн инженер Ш.Бумандолгор, Хувиараа хөдөлмөр эрхлэгч Т.Мөнхбаяр, Б.Мөнхбат нар, "Их сумт хайрхан" ХХК захирал Б.Доржгив, "Их дөлгөөн хангай" ХХК захирал Р.Болормаа нар, нийтийн сонсголын оролцогчоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ж.Ганчулуун, Д.Бямбасүрэн, С.Төмөр нар, шинжээчээр санхүү төрийн сангийн мэргэжилтэн Э.Дашдулам, ажиглагчаар 31 иргэн, албан хаагч оролцлоо. Сонсголын үйл ажиллагааг нээж ИТХ-ын дарга Ц.Чинбаяр үг хэллээ.

ХЭЛЭЛЦСЭН нь:

Ц.Чинбаяр /ИТХ-ын дарга/: Нийтийн сонсголын гол зорилго нь иргэдийг мэдээллээр хангаж, оролцоог нэмэгдүүлэх, Нийтийн сонсголын хууль холбогдох журмын хэрэгжилтийг хангахад оршино. Нийтийн сонсголыг 7 дах удаагаа зохион байгуулж байна. Сонсгол нь хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулдаг. Нийтийн сонсголоор ямар нэгэн шийдвэр гардаггүй, мэдээ мэдээллийг өгдгөөрөө онцлог юм аа. Захиргааны хэм хэмжээ тогтоох сонсголыг зохион байгуулж болно. Өнөөдөр Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 2024 оны хэрэгжилт, зарцуулалт, гүйцэтгэлийн тухайн төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулж байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг уриалж байна.

Г.Ганчимэд \Сонсгол даргалагч/: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан Сумын ИТХ-ын Нийтийн сонсголыг дэгийг уншиж танилцуулав. /Дэгийг хавсаргав/

Нийтийн сонсгол хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан хаагч, сонсголд оролцогчид үг хэлэхдээ 5 минут, амаар болон бичгээр асуулт асууж болно. Асуулт 4 минут, дараагийн удаа 1 минут, үг хэлэхдээ 3 минут байна.

Ажиглагчид үг хэлж, асуулт асуухгүй. Ингээд үйл ажиллагаандаа оръё. Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Янжиндулам Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг танилцуулна.

Б.Янжиндулам Дуудагдсан албан тушаалтан, Байгаль орчний хяналтын улсын байцаагч \: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг танилцуулъя. Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 2024 онд 1,392,676,700 төгрөгийн санхүүжилт авсан байгаа. Үүнээс бид нийт 35 ажил төлөвлөснөөс 26 ажил хийгдэж 4 ажил он дамнаж 5 ажил нь огт зарлагдаагүй байна. Хуш модны самрын нөөц тогтоох шаардлагатай техник хэрэгслээр хангах төсөв өртөг 15,000,000 Их говийн мандах булаг каспанитай хамтарч ажилласан. Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр мөчир үржүүлэх хүлэмж худалдан авах 2 арга хэмжээ төсөвт өртөг 24,500,000 Нарлаг ган хүлэмжтэй хамтран ажилласан. Мод үржүүлгийн газарт хөрс боловсруулах тарьц суулгацын нөөц хадгалах зоорь барих төсөвт өртөг 19,800,000 төгрөг төсвөлсөнөөс 19,700,000 төгрөгөөр иргэн Мөнхбаяртай гэрээ байгуулж ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц суулгацыг худалдан авах төсөвт өртөг 15,000,000 төргөөр сум дундын ойн анги хийж гүйцэтгэсэн. Мод үржүүлгийн газрын усалгааны системийг шинэчлэх төсөвт өртөг 12,700,000 Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрыг өргөтгөх ажилд дэмжлэг үзүүлэх төсөвт өртөг 18,000,000 Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх төсөвт өртөг 19,500,000 Ой хээрийн түймэр хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгаль хамгаалагчийн хувцас тоног төхөөрөмжөөр хангах төсөвт өртөг 19,800,000 Доройтсон ойд “Ойжуулалт” нөхөн сэргээх, үржүүлэх ажил төсөвт өртөг 70,000,000 Сумын төвийн шинэ суурьшлын бүсэд шинээр байгуулагдах цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих, нийтийн нийтийн эзэмшлийн талбай хашаа засварлах төсөвт өртөг 70,000,000 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны “ТЭЗҮ боловсруулах” төсөвт өртөг 20,000,000 Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төсөвт өртөг 8,000,000 “Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийг байгальд тархахаас сэргийлэх” ажил зохион байгуулах 20,000,000 Нэн ховор, ховор амьтдад биотехникийн арга хэмжээ зохион байгуулах 15,000,000 Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ногоон байгууламжууд хариуцах, ойжуулалт ой, хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх пост ажиллуулах, хуурайшилтын улирал эхлэхээс өмнө ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх аян зохион байгуулах мод хуш модны самар бэлтгэх зэрэг үед идэвхтэн байгаль хамгаалагч албан хаагч ажиллуулах байгалийн нөөцийг хамгаалах зохистой ашиглах талаарх нутгийн иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах 39,000,000 Хууль бус мод хуш модны самар бэлтгэхээс урьдчилан сэргийлэх ойжуулалт хийх бусад хяналт шалгалтыг хийхэд албан хаагчдыг унаажуулах төсөвт өртөг 33,000,000 Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэл, хуш модны самар бэлтгэхээс явуулын хяналтын пост байгуулах төсөвт өртөг 20,000,000 Байгаль хамгаалах аян зохион байгуулах төсөв өртөг 22,176,700 Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр төрөл бүрийн аян зохион байгуулах, хяналт шалгалт хийх, ойн хээрийн түймрийн онцгой нөхцөлд ажиллах албан хаагчдын албан томилолт зардал санхүүжүүлэх төсөвт өртөг 15,000,000 Ойн, хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сааруулах, хамгаалах, тэмцэх зорилгоор гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх төсөвт өртөг 20,000,000 Усны хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэлд хийх төсөвт өртөг 2,000,000 Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүргийн шүршигч багажаар “Хортон устгалын ажил” төсөвт

өртөг 315,000,000 Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүргийн шүршигч багажаар “Хортон устгалын ажлыг 2024 оны 07 сарын 03-ны өдөр “Гранд форест” ХХК гэрээ байгуулж нийт 7875 га талбайд 303,000,000 сая төсөвт өртөгтэй тэмцлийн ажил гүйцэтгэсэн. Сумын төвд ногоон байгууламж нэмэгдүүлэх төсөвт өртөг 110,000,000 Багц 1- Төмөр хайсан хашаа барих, хүйтэн булаг эхийг модон материалаар хийх ажлыг “Жаргалант хүлэмж” ХХК-тай 2024 оны 07 сарын 09 өдөр 62,080,507 төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээ байгуулж урьдчилгаа санхүүжилт 70 хувь буюу 43,456,354 төгрөгийг авсан. Үлдэгдэл санхүүжилтийг/ ажлуудыг бүрэн хийж дуусаагүй тул дараах ХХК-д удаа дараа шаардлагыг тавьсаар байна. Багц 2- Ногоон байгууламжид суулгац, цэцэг нийлүүлэх, мод тарих ажилд “Их сумт хайрхан” ХХК нь 2024 оны 07 сарын 09-ны өдөр 40,598,910 төсөвт өртөгтэй гэрээ байгуулж ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн

Г.Ганчимэд\Сонсгол даргалагч\: Б.Янжиндуламдаа баярлалаа. Оролцогчид 5 минутад багтааж үг хэлнэ. Мэдээлэлтэй холбоотой асуулт, санал байна уу.

Д.Бямбасүрэн\оролцогч\: 1. Сумын төвд ногоон байгууламж нэмэгдүүлэхэд 110 сая төгрөг тавьсан байна. Энэ ажилд 2 компани орсон байна яагаад одоо болтол ажилыг хийж гүйцэтгэж дуусахгүй байна вэ?

2. Хүйтэн булагийн тархийг одоогоор төмөр хашаагаар хашсан байгаа яагаад модон хашаагаар хашсан гэж танилцуулсан бэ?

Г.Ганчимэд \Сонсгол даргалагч\: Оролцогч Д.Бямбасүрэнгийн асуултад Сум дундын ойн ангийн дарга Д.Очирхуяг мэдээлэл өгнө үү.

Д.Очирхуяг \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Сум дундын ойн ангийн дарга \: Уг ажилыг 2 хэсэг болгон тендер зарласан. Үүнд “Их сумт хайрхан”, “Жаргалан хүлэмж” гэсэн 2 компани шалгарч одоогоор Их сумт хайрхан компани ажлаа 80 хувь хийж гүйцэтгээд байна. “Жаргалан хүлэмж” компанийн нийлүүлж буй мод хамгаалах хашлага төмөр нь 360 ширхэг ирэхээс одоогоор 160 ширхэг ирээд байна. Энэ бүгдийг нийлүүлээд суурилуулаад дуусвал “Их сумт хайрхан” компани нь мод суулгах ажлыг хийж гүйцэтгэнэ. 2 дахь асуултанд бол Хүйтэн булагийн хашаа бол одоогоор хийгдээгүй байгаа цаашдаа хийх төлөвлөгөөтэй байгаа.

Г.Ганчимэд \Сонсгол даргалагч\: За баярлалаа. Дараагийн оролцогч С.Төмөр төлөөлөгчийг урьж байна.

С.Төмөр \оролцогч\: 1. Хог ангилан ялгах, 2 дахь түүхий эдийн цэг бий болгох Тоног төхөөрмж авах энэ ажил яагаад хийгдээгүй вэ?

2. Шинэ сумын төвийн ногоон байгууламж хаана хийгдэж байгаа вэ?

Г.Ганчимэд \сонсгол даргалагч\: С.Төмөр төлөөлөгчийн асуултад сум дундын Ой агийн дарга Д.Очирхуяг, сумын Засаг дарга Н.Орхонтуул нар хариулна уу.

Д.Очирхуяг \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\: Шинэ сумын төвийн ногоон байгууламж наадмын талбайн урд 1 га газар хашаалаад будсан байгаа.

Н.Орхонтуул \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\ Хогийн ангилан ялгах, 2 дахь түүхий эдийн цэг бий болгох ажил нь 2024 ондоо амжиж тендерээ зарлаж чадаагүй юм аа. Бид бүхэн энэ жил зарлах гээд ажиллаж байна.

Г.Ганчимэд \сонсгол даргалагч\: Оролцогч Ж.Ганчулуун төлөөлөгчийг урьж байна.

Ж.Ганчулуун \оролцогч\: 1. Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэж байна. Энэ талаар дээр ямар ажлууд хийгдсэн бэ?

2. Манай сумын хувьд хог хаягдал хамгийн тулгамдаж буй асуудал яагаад энэ ажлуудыг хэрэгжүүлэхгүй үлдээсэн бэ? ганцхан менежментийн төлөвлөгөө хийсэн байна. Энэ асуултанд хариулж өгнө үү.

Г.Ганчимэд \Сонсгол даргалагч\ Ж.Ганчулуун төлөөлөгчийн асуултад сум дундын Ой ангийн дарга Д.Очирхуяг хариулт өгнө үү.

Д.Очирхуяг \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\ Нөхөрлөл дэмжих 8,000,000 сая төгрөгөөр бол халцарсан хуш мод будсан байгаа. энэ ажлыг “Их сумт хайрхан” ХХК хийж гүйцэтгэсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 85 хувь нь байгаль руугаа чиглэдэг хуультай. Хогны асуудал дээр бол сумын тулгамдаж буй асуудал учир бид бүхэн мөнгийг нь тавьж өгсөн. Иймд тухайн тендерыг зарлах ажлын хэсгийн хүмүүсээс асууна уу.

Санал дүгнэлт:

Д.Бямбасүрэн \Оролцогч\ Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалтай холбоотой зөндөө асуух асуулт байна гэхдээ сонсголын хүрээндээ асуултаа асуулаа. Байгаль орчин руугаа чиглэсэн сайхан ажлууд их хийсэн байна. Анхаарах зүйл сумын хог хаягдал руу чиглэсэн ажлыг эрчимтэй хийж гүйцэтгэмээр байна. Өөрөөр ноцтой зөрчил байхгүй байна

Г.Ганчимэд \сонсгол даргалагч\ За баярлалаа. Оролцогч С.Төмөр төлөөлөгч танийг урьж байна.

С.Төмөр \Оролцогч\ Ноцтой алдаа зөрчил байхгүй байна гэж үзэж байна.

Г.Ганчимэд \сонсгол даргалагч\ За баярлалаа. Оролцогч Ж.Ганчулуун төлөөлөгчийг урьж байна.

Ж.Ганчулуун \Оролцогч\ Сумын төвийн ногоон байгууламжийг эрчимжүүлэх хог хаягдал руу чиглэсэн батлагдсан өртөгтэй ажлуудыг хийж гүйцэтгэх анхаарал тавих нийт хийж гүйцэтгэсэн ажлуудыг 82 хувьтай гэж дүгнэж байна.

Г.Ганчимэд \сонсгол даргалагч\ Санал хариулт авч дууслаа. Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон нийт оролцогчдодоо баярлалаа.

Ц.Чинбаяр\зохион байгуулагч\ Сонсгол энэ хүрээнд өндөрлөж байна.

Байгаль орчин нөхөн сэргээх зардлын 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар өнөөдрийн Нийтийн сонсголд оролцсон ажиглагчид тодорхой хэмжээний чиглэл, ойлголттой боллоо.

Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэд та бүхэндээ баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Нийтийн сонсгол 13:07 цагт өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:


ИТХ-ЫН ДАРГА  Ц.ЧИНБАЯР



ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ОЛОН НИЙТТЭЙ

ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ДААРИЙМАА